

**ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ**

2018 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар хот

Иргэд, аж ахуйн нэгжүүд болон ажилтан, албан хаагчдаас жилийн хугацаанд нийт 236 өргөдөл хүсэлт ирсэнээс 230 өргөдөл, хүсэлтийг өргөдөл гомдлын нэгдсэн систем www.smartcity.mn цахим санд бүртгэж, шийдвэрлэлээ. Харин Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 03/4670 дугаар албан бичгийн дагуу 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс хойш байгууллагад ирсэн өргөдөл хүсэлтийг www.erp.ulaanbaatar.mn дотоод удирдлагын системд бүртгэн, холбогдох албан тушаалтанд программын тусламжтайгаар илгээн, хуулийн хугацаанд, эрх зүйн үндэслэлтэйгээр шийдвэрлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд газрын хэмжээнд ирсэн 234 (99,1%) өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн, шийдвэрлэгдэх шатанд буюу хугацаа болоогүй 2 (0,9%) өргөдөл байна. Мөн хугацаанд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн болон хугацаа сунгаж шийдвэрлэсэн өргөдөл хүсэлт байхгүй болно.

Өргөдөл гомдлын хандалтыг өмнөх жилүүдтэй харьцуулсан байдал

Д/д	Хандалтын төрөл	2016 он	2017 он	2018 он
1	Хөдөлмөрийн хөлсний тухай	12	126	35
2	Захиргааны чөлөө хүсэх тухай	6	66	57
3	Ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх тухай	7	49	72
4	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	-	7	11
5	Жирэмсний болон ээлжийн амралтын тухай	-	16	22
6	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	2	21	32
7	Ажлын сахилга хариуцлагын тухай	3	7	1
8	Агентлагуудын үйл ажиллагааны тухай	196	-	-
9	Бусад асуудлаар	6	4	6
Нийт		232	296	236

Газрын хэмжээнд 2018 онд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 11 цаг 25 минут байгаа нь 2017 оны мөн үеийнхтэй харьцуулахад 2 хоног 7 минутаар, өргөдөл гомдлын хандалтын тоо 21 хувиар буурчээ.

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хугацааг өмнөх жилүүдтэй харьцуулсан байдал

Д/д	Шийдвэрлэлтийн дундаж хоног	Өргөдөл, гомдлын тоо			Эзлэх хувь		
		2016 он	2017 он	2018 он	2016 он	2017 он	2018 он
1	5 хоногт	165	164	179	71,74%	55,41%	75,78%
2	10 хоногт	48	89	32	20,87%	30,07%	13,83%
3	15 хоногт	13	24	12	5,65%	8,45%	5,19%
4	30 хоногт	4	18	12	1,74%	6,08%	5,19%
Нийт		230	296	234	100%	100%	100%

